3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Арьсны өвчин судлалын үндэсний төв нь захирлын 2022 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/02 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тус төвийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 201,093.9 мянган төгрөгөөр буюу 4.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	110,831.8	179,891.3	69,059.5
Авлага	270.2	40,431.9	40,161.7
Урьдчилгаа	13,965.0	-	(13,965.0)
Бараа материал	328,617.0	291,245.0	(37,372.0)
Үндсэн хөрөнгө	4,349,344.1	4,492,553.6	143,209.5
Нийт хөрөнгө	4,803,028.1	5,004,122.0	(201,093.9)
Өр төлбөр	5,249.6	732,582.6	(727,333.0)
Засгийн газрын хувь оролцоо/эздийн өмч	4,797,778.5	4,271,539.3	(526,239.2)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,803,028.1	5,004,122.0	(201,093.9)

Дээрх хүснэгтээс харахад, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данисуудад нөлөө бүхий өөрчлөлтүүд гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 179,891.3 мянган төгрөг болж өмнөх оноос 69,059.5 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн яамнаас 2024 оны 12 дугаар 03-ны өдөр сервер худалдан авах зориулалтаар 150,000.0 мянган төгрөг шилжүүлснээр тендер зарлаж "Би Си Ти" ХХК-тай гэрээ хийсэн боловч санхүүжилтийг олгоогүй;

Авлага дансны үлдэгдэл 40,431.9 мянган төгрөг болж 40,161.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах төлбөртэй үйлчилгээний авлага 40,431.9 мянган төгрөгийн авлага бүртгэсэнтэй холбоотой;

Урьдчилгаа дансны үлдэгдэл өмнөх онд 13,965.0 мянган төгрөг байсан бөгөөд тайланд онд эхоны датчик, ус нэрэгч аппарат зэрэг тоног төхөөрөмжийг худалдан авч орлого болгосонтой холбоотой;

Бараа материал дансны үлдэгдэл 291,245.0 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 37,372.00 мянган төгрөгөөр буурахад, худалдан авсан 1,474,950.4 мянган төгрөг, дээд шатны төсөв захирагчийн тушаал шийдвэрээр үнэ төлбөргүй шилжиж ирсэн 28,525.5 мянган төгрөгийн бараа материал орлого авсан дүнгээр нэмэгдэж, байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан 1,516,511.9 мянган төгрөгөөр хасагдсан нь нөлөөлсөн;

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,492,553.6 мянган төгрөг болж өмнөх оноос 143,209.5 мянган төгрөгөөр өсөхөд, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 82,340.5 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 785 дугаар тогтоолын дагуу хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоосон 217.5 мянган төгрөг, ЭМС-ын 2024 оны А/245 дугаар тушаалаар төвийн лабораторийн барилгад их засвар хийж 412,449.8 мянган төгрөгийн өртгийг капиталжуулснаар тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2023 оны 807 дугаар тогтоолоор акталж, данс бүртгэлээс хассан 181,455.5 мянган төгрөгөөр хасагдсан нь нөлөөлсөн;

Өр төлбөр дансны үлдэгдэл 732,582.6 мянган төгрөг болж 727,333.0 мянган төгрөгөөр өссөн ЗГ-ын 128 дугаар тогтоолын хүрээнд үндсэн цалин 10-20 хувиар нэмэгдэж, НДШ 131,856.5 мянган төгрөг, ХХОАТ 214,492.7 мянган төгрөг болон эм, эмнэлгийн хэрэгслийн ханган нийлүүлэх байгууллагад 386,233.3 мянган төгрөгийн өглөг тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4,271,539.3 мянган төгрөг болсон нь тайлант жилийн үр дүн буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвийн ТУЗ-ийн 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 3 дугаар тогтоолоор 2024 оны төсвийн төсөлд Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр 5,127,950.8 мянган төгрөг, үйл ажиллагааны болон туслах үйл ажиллагааны орлогоос 1,140,000.0 мянган төгрөг, өмнөх оны үлдэгдлийн 112,000.0 мянган төгрөг нийт 6,379,950.8 мянган төгрөгөөр орлогыг бүрдүүлж нийт зарлагыг санхүүжүүлэхээр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт орлого, зардлыг 1,576,362.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 7,956,313.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг ТУЗ-ийн баталсан дүнгээс 1,693,240.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт 2 удаа тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн хүрээнд 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр эрүүл мэндийн даатгалын сангаас 5,968,979.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,080,000.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 931,813.4 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 92,397.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр байна.

ТУЗ-өөр баталсан төсвийг зардлын эрх нээх бүрд удаа дараа шинэчлэн өөрчилж байгаа асуудал нь төсвийг бодит тоо мэдээ, судалгаанд үндэслэж боловсруулж баталдаггүйгээс шалтгаалж байна.

аудитор М.Пагамдулам, аудитын менежер В.Эрдэнэцогт, Санхүү-нийцлийн газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/33 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 7,375,532.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 73,755.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой тээвэр шатахууны зардлыг 980.4 мянган төгрөгөөр, гадаад болон дотоод томилолтын зардлыг 3,960.0 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 2,462.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хамруулж, үндсэн хөрөнгө, бараа материал, богино хугацаат өр төлбөр, авлага данстын хувьд горим, сорил хэрэгжүүлж Нийгмийн даатгалын тайланд тайлагнасан нийт цалингийн дүн нь санхүүгийн тайлан, журналд бүртгэсэн цалингийн өглөгөөс зөрүүтэй байсан 6,369.8 мянган төгрөгийн 1 алдааг илрүүлж, жилийн эцсийн санхүүгийн тайлангаар залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүйтэй холбоотой 2 албан шаардлага, орлого бүрдүүлэлт, дотоод хяналттай холбоотой 2 зөвлөмжийг хүргүүлснээс зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 5,129.1 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжиж 1 зөвлөмж хэрэгжих шатандаа байгаа тул хэрэгжилтийг 87.5 хувиар үнэллээ.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	-	2	-	100.0
Зөвлөмж	2	5,129.1	2	5,129.1	75.0
Нийт дүн	4	5,129.1	4	5,129.1	87.5

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,369.7 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 6,369.7 мянган төгрөгийн 1 алдааг залрууллаа.

- Нийгмийн даатгалын тайланд тайлагнасан нийт цалингийн дүн санхүүгийн тайлан, журналд бүртгэсэн цалингийн өглөгөөс 6,369.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;

Энэ нь УСНББОУС-1-ийн 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг" гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй.

Аудитаар нийт 29,326.9 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 29,326.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 3 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 29,326.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 44,428.4 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Тус төвийн захирал болон Үйлдвэрчний эвлэлийн хорооны даргын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 2023-2024 оны хамтарсан хэлэлцээрийн 3.11-д "...тасгийн эрхлэгч, ахлах сувилагч нарт хариуцлагын нэмэгдлийг үндсэн цалингийн 25 хувь, хөрөнгийн бүрэн бүтэн хариуцлагын гэрээтэй эд хариуцагч нарт үндсэн цалингийн 10 хувийн нэмэгдэл хөлс, ёс зүйн нэмэгдэл олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар хамтран ажиллана" гэсэн заалтын дагуу нийт 29,326.9 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон байна. Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5 "Эрүүл мэндийн ажилтанд хууль тогтоомжид заасны дагуу цалин хөлсний нэмэгдэл, мөнгөн урамшуулал олгох бөгөөд тэдгээрийн төрөл, хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална" заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2-т зааснаар "Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай" гэсэн заалттай нийцээгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан цалингийн нэмэгдлээс бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшуулал олгосон зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх шаардлага хүргүүлэх.

2. Тайлант жилд үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг нэр төрлөөр зөв ангилан бүртгээгүй, "ҮҮАО" гэсэн нэрээр нэг дансанд бөөн дүнгээр нийт 1,111,125.4 мянган төгрөгийн орлогыг бүртгэж тайлагнасан байна. Энэ нь "Сангийн сайдын 2023 оны 211 тоот тушаалаар батлагдсан "Орлогын эдийн засгийн ангилал батлах тухай журам"-д заасан төсвийн байгууллагын орлогын ангилал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.үнэн зөв байх, 5.1.5.хэмжигдэхүйц байх" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн ба туслах үйл ажиллагааны орлогыг нэг дансанд бөөн дүнгээр бүртгэж байгаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 151,465.0 мянган төгрөгийн 16 ширхэг хөрөнгийн цаашид ашиглах хугацаа, шинэчлэн тогтоох үнийг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" НББ-ийн тухай хуулийн 5.1.5 "хэмжигдэхүйц байх", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дугаар тушаалын 7.1 "Элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох" гэсэн заалт болон "УСНББОУС 17 Үндсэн хөрөнгө" гэсэн стандартын заалттай тус тус нийцээгүй, ангилал ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн ашиглалт, өртөг нөхөлтөд хяналт тавьж, үнийг шинэчлэн тогтоох асуудлыг эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Төлбөртэй өрөөний орлогын тайлантай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Төлбөртэй өрөөнөөс олсон орлогын гүйцэтгэлийг тулган баталгаажуулахад төлбөртэй өрөөнд бусдаас ялгагдаж танигдах дугаарлалт байхгүй, хэвтсэн өвчтөний түүх дээр өрөөний дугаар тавьдаггүй, орлогын тайлан гаргадаггүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Эрүүл мэндийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/216 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-ын 2.5 "Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээнээс олсон орлогыг эрүүл мэндийн байгууллагын цахим бүртгэлийн болон санхүүгийн программд бүртгэж, тайлагнаж ажиллана" 3.1-д "Эрүүл мэндийн байгууллага нь ... үйлчлүүлэгчийг албан бус төлбөр төлөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна" гэсэн заалтуудтай нийцээгүй, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна. Энэхүү зөрчил нь төлбөртэй өрөөний орлогод дүн шинжилгээ хийх, хянах боломжгүй болгох үр дагавартай байна.

Өгсөн зөвлөмж: Төлбөртэй өрөөний дугаар, үйлчлүүлсэн өвчтөний мэдээлэл, хугацаа зэрэг ялгаж таних тэмдэг бүхий мэдээллийг тодорхой болгож, орлогын тайланг сар бүр гаргаж, хяналт тавьж ажиллах;

3. Баримтын бүрдүүлэлтэд тавих дотоод хяналттай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

“ЭМДЕГ-ын чанарын болон төлбөрийн хяналтаар тус төвийн баримтын бүрдүүлэлтэд тавих хяналт хангалтгүйгээс /цахим хяналтын хасагдал 50,517.1 мянган төгрөг, эмчийн болон эх олонлогийн түүврийн хасагдал 228,622.5 мянган төгрөг/ шалтгаалан ЭМДС-аас авах санхүүжилтийг нэхэмжилсэн дүнгээс 279,139.6 мянган төгрөг буюу 5.6 хувийн санхүүжилт хасагдсан бөгөөд нягтлан бодох бүртгэлд бүртгэж, санхүүгийн тайланд тайлагнахгүй байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3.даатгуулагчийг төлөөлж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай тусламж, үйлчилгээний зардлын төлбөр тооцоо хийх гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавих, дүгнэх” гэсэн заалтуудтай нийцээгүй, ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолын шалгуур хангаагүй, хяналт тавиагүй байна.

Өгсөн зөвлөмж: ЭМДС-аас авах эмнэлгийн тусламжийн үйлчилгээний санхүүжилтийн нэхэмжлэхийн бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, шалгуурыг хангуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			Зөвлөмж	
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Зөвлөмж	Тоо	Дүн
НД-ын тайланд тайлагнасан нийт цалингийн дүн нь СТ, журналд бүртгэсэн цалингийн өглөгийн дүнгээс зөрүүтэй тайлагнасан	1	6,369.7			1	6,369.7					
Дүн	1	6,369.7			1	6,369.7	1	6,369.7			

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хууль тогтоомжид заагаагүй нэмэгдэл олгосон	1	29,326.9			1	29,326.9						
"Төсвийн орлогын эдийн засгийн ангилал"-ыг мөрдөөгүй	1	-			1	-						
16 ш хөрөнгийн цаашид ашиглах хугацаа, шинэчлэн тогтоох үнийг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлээгүй	1	-						1	-			
Төлбөртэй өрөөний орлогын тайлан гаргадаггүй	1	-						1	-			
ЭМДС-ийн санхүүжилтийн хасагдсан дүнг НББ-д бүртгэж, санхүүгийн тайланд тайлагнаагүй	1	-						1	-			
Дүн	5	29,326.9			2	29,326.9	3	-				



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 174/АОВОР25

Улаанбаатар хот

Сн/г- 2025/285/НА-СТН-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант жилд үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг нэр төрлөөр зөв ангилан бүртгээгүй, "ҮҮАО" гэсэн нэрээр нэг дансанд бөөн дүнгээр нийт 1,111,125,400.00 /Нэг тэрбум нэг зуун арван нэгэн сая нэг зуун хорин таван мянга дөрвөн зуун/ төгрөгийн орлогыг бүртгэж тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. "үнэн зөв байх", 5.1.5. "хэмжигдэхүйц байх", 18 дугаар зүйлийн 18.1. "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын үйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.4. "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэх байгаа эсэхийг хянах", Сангийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн орлогын эдийн засгийн ангилал"-тай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн, алдаа зөрчлийг таслан зогсоож давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Орлогыг дэд дансаар ангилж бүртгээгүй, нэг дансанд бөөн дүнгээр бүртгэж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Арьсны өвчин судлалын үндэсний төвийн захирал /Ц.Уранчимэг/, Санхүү бүртгэлийн албаны дарга /Б.Мядаг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"ТЭД-АУДИТ" ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Ц.СУГАРМАА
АТАСАН 02.05.2025
9023200522

1505000355



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 175/АД/5085

Улаанбаатар хот

СНӨГ-2025/085/НА-СТД-ПМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төвийн захирал болон Үйлдвэрчний эвлэлийн хорооны даргын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 2023-2024 оны хамтарсан хэлэлцээрийн 3.11-д "тасгийн эрхлэл, ахлах сувилагч нарт хариуцлагын нэмэгдлийг үндсэн цалингийн 25 хувь, хөрөнгийн бүрэн бүтэн хариуцлагын гэрээтэй эд хариуцагч нарт үндсэн цалингийн 10 хувийн нэмэгдэл хөлс, ёс зүйн нэмэгдэл олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар хамтран ажиллана" гэсэн заалтын дагуу эхний 3 сарын байдлаар нийт 29,326,900.00 /хорин есөн сая гурван зуун хорин зургаан мянга есөн зуун/ төгрөгийн нэмэгдэл олгосон нь Засгийн газрын тогтоолоор батлагдсан нэмэгдлүүдэд хамаарахгүй бөгөөд хариуцлагын нэмэгдэл олгох журам батлаагүй байна.

Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5-д "Эрүүл мэндийн ажилтанд хууль тогтоомжид заасны дагуу цалин хөлсний нэмэгдэл, мөнгөн урамшуулал олгох бөгөөд тэдгээрийн төрөл, хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална", Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2-т "Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн, алдаа зөрчлийг таслан зогсоож давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлаагүй нэмэгдэл хөлс, урамшуулал олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт¹ ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Арьсны өвчин судлалын үндэсний төвийн захирал /Ц.Уранчимэг/, Санхүү бүртгэлийн албаны дарга /Б.Мядаг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"ТЭД-АУДИТ" ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Ц.СУГАРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264231

Z:\Alban Shaardlaga\2025\0225 SNAG-21.Docx

1525200853

This image shows a full page of a document template designed for handwritten notes or answers. It features approximately 28 evenly spaced horizontal dashed lines across the entire width of the page, providing a guide for letter height and placement. The background is plain white, and there are no margins, headers, or footers visible.

This image shows a single sheet of white paper with horizontal ruling lines. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.

Утас: +976 51 261585

Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр

Бага тойрог-3, Цогцолтой аймаг